

АЖЛЫН ДААЛГАВАР

Судалгааны ажлын
зорилго:

Авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн
төлүүлэхэд

- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,
- Төрийн аудитын байгууллагыг

нэхэмжлэгчээр тогтоох эрх зүйн үндэслэл, шалтгаан, зохистой байдлыг судлан дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, шаардлагатай бол дүгнэлтийг үндэслэн холбогдох байгууллагуудад зөвлөмж, санал хүргүүлэх.

Хугацаа:

Ажлын 60 хоног

Эхлэх хугацаа:

2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

Дуусах хугацаа:

2026 оны 08 дүгээр сарын 24-ны өдөр

Байршил:

Авлигатай тэмцэх газар

1.	Судалгааны ажлын сэдэв	Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллагыг нэхэмжлэгчээр тогтоох үндэслэл шалтгааныг судлах
2.	Үндэслэл	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 7.5.1.1-д “Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудалд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн аудитын байгууллагыг нэхэмжлэгчээр тогтоох үндэслэл, шалтгааныг судлах ажил тусгагдсан.
3.	Зөвлөхийн гүйцэтгэх ажил	Гүйцэтгэгч нь судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд: 1) Авлигын гэмт хэрэгт хохирол тооцох, тогтоох, нөхөн төлүүлэхтэй холбоотой одоогийн эрх зүйн зохицуулалтыг (Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн сангийн тухай хууль гэх мэт) шинжилж үнэлэх. 2) Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон төрийн аудитын байгууллагын хохирлыг төлүүлж нэхэмжлэх эрх зүйн үндэслэл, хязгаарлалтыг судлах.

		<p>3) Олон улсын жишиг, туршлагаас (OECD, UNODC, бусад улс орнуудын практик) харьцуулсан судалгаа хийж дотоод зохицуулалтыг сайжруулах боломжийг тодорхойлох.</p> <p>4) Авлигын гэмт хэргийн хохирлыг үр дүнтэй нөхөн төлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд бодлогын болон эрх зүйн зөвлөмж, санал боловсруулж дүгнэлт гаргах.</p>
4.	Зөвлөхөд тавигдах шаардлага	<p>Ерөнхий шаардлага: Зөвлөх нь дараах мэргэжил, туршлага байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хууль, эрх зүй болон бусад холбогдох нийгмийн шинжлэх ухааны чиглэлийн мэргэжилтэй байх; 2. Монгол Улсын засаглалын тогтолцоо, хууль, эрх зүйн орчны талаар мэдлэгтэй байх; 3. Бодлогын шинэчлэл, авлигатай тэмцэх, сайн засаглалын чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаанд оролцож, үр дүн гаргасан байх (давуу тал болно); <ul style="list-style-type: none"> • Ижил төстэй судалгаа шинжилгээ, үнэлгээний ажил удирдан зохион байгуулж, үр дүн гаргасан байх (давуу тал болно); <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн, ажлын дадлага, туршлагатай, ажлын даалгаврыг бүрэн гүйцэтгэх хангалттай мэдлэг, ур чадвартай зөвлөх байх;
5.	Удирдлага зохион байгуулалт	Гүйцэтгэгч нь Авлигатай тэмцэх газрын холбогдох нэгжтэй нягт хамтран ажиллаж, ажлын явц, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнана.
6.	Тайлангийн хуваарь	Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш долоо хоног тутамд ажлын явцын тайланг захиалагчид танилцуулна.
7.	Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн	Судалгааны тайлан, зөвлөмж, санал
8.	Төлбөрийн нөхцөл	Ажлын хөлсийг гэрээнд заасны дагуу төлнө. Төлбөрийг төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.
9.	Баталгаат хугацаа	Судалгааны ажлыг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 1 сарын хугацаанд зөвлөгөө, тодруулга өгөх байдлаар баталгаат үйлчилгээ үзүүлнэ.